

ТӨСЛИЙН НЭГЖИД АЖИЛТАН ШАЛГАРУУЛЖ АВНА

Монгол Улсын Засгийн газар Европын холбоо, Европын сэргээн босголт, хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж байгаа “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн хүрээнд Орхон аймгийн Баян-Өндөр суманд ажиллах “Төсөл хэрэгжүүлэх нэгж”-д дараах ажлын байранд ажилтан шалгаруулж авна. Үүнд:

1. Төслийн менежер бөгөөд техникийн мэргэжилтэн
2. Байгаль орчны болон нийгмийн ажилтан
3. Санхүүгийн ажилтан

Сонгон шалгаруулалтад орох хүсэлтэй иргэд дараах баримт бичгүүдийг бүрдүүлж

Орхон аймаг, Баян-Өндөр сум 61020
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон,
ЗДТГ, ХБТХОХ 202 тоот

шуудангийн хаягаар эсвэл info@orkhon.gov.mn мэйл хаягаар ирүүлнэ үү.

Утас: 976 - 7035 9168

Бүрдүүлэх бичиг баримт:

1. Товч намтар /CV/
2. Дипломын хуулбар
3. Иргэний үнэмлэхний хуулбар
4. Өмнөх ажил олгогчийн тодорхойлолт /2-оос доошгүй/
5. Англи хэлний болон холбогдох мэргэжлийн ур чадварыг илэрхийлэх бусад баримт бичгүүд
6. Төрийн албан хаагчийн анкет /загварыг татаж бөглөж ирүүлэх/

Материалыг 2023 оны 10 дугаар сарын 04-ний 17:00 цаг хүртэл хүлээн авна.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын ажлын байранд тавигдах шаардлага

1.Төслийн менежер бөгөөд техникийн мэргэжилтэн

Хийх ажлын цар хүрээ

Төслийн менежер нь Зээлдэгч /Монгол Улсын Сангийн яам/, Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар, Европын сэргээн босголт хөгжлийн банк /ЕСБХБ/, Төслийн хэрэгжилтийг дэмжих , Хөгжлийн хөтөлбөрийн зөвлөхүүд болон төслийн бусад оролцогч талууд, төслийн гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид хоорондын ажлын уялдаа холбоог хангахын зэрэгцээ төсөл хэрэгжүүлэх нэгжийн өдөр тутмын удирдлага, ажилтан нарын ажлын гүйцэтгэлийг хариуцна.

Төслийн менежерийн үндсэн чиг үүрэгт дараах асуудлууд орно. Гэхдээ чиг үүрэг үүгээр хязгаарлагдахгүй.

Дэлгэрэнгүй чиг үүрэг:

- Төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Сангийн яам, Орхон аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, ЕСБХБ, төрийн бус байгууллага/иргэний нийгмийн байгууллагууд, түүнчлэн Төслийн хэрэгжилтийг дэмжих, хөгжлийн хөтөлбөрийн зөвлөхүүд гэх мэт бүх оролцогч талуудтай нягт уялдаа холбоотой хамтран ажиллах,
- Төслийн жилийн тайлан, төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, жилийн болон улирал, сар бүрийн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах, үнэлгээний тайланг бэлтгэхэд төслийн зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, төслийн тайлан, үнэлгээний үр дүнг Орхон аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, Төслийн удирдах хороо, ЕСБХБ-нд хэлэлцүүлэх уулзалт, хэлэлцүүлгийн үеэр Төслийг төлөөлөх үндсэн гол үүргийг гүйцэтгэх,
- Төслийн хүрээнд хэрэгжиж буй бүх үйл ажиллагааны явцыг холбогдох хууль тогтоомж, ЕСБХБ-ны журмын шаардлагад нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих /үүний дотор нийгэм, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хэрэгжилт орно/,
- Төслийн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд нь гүйцэтгэхэд шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах, хэрэгжилтийн явцыг тогтмол хянах,
- Төсөл хэрэгжүүлэх нэгж /ТХН/-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны үр нөлөөг үнэлэх (төслийн ажилтнуудын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, санал хүсэлтийг оролцуулан), шаардлагатай бол өөрчлөлт оруулах зөвлөмж гаргах,
- Тендер шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, зөвлөхүүдийн саналыг үнэлэхэд оролцох,
- Гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, зөвлөхүүдийн ажлын үнэлгээнд оролцох, зөвлөхүүдийн тайланг цаг тухайд нь хүлээн авч, санал зөвлөмж өгөх,
- ЕСБХБ-ны төлөөлөгчид болон холбогдох аудитуудыг төслийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардагдах материалыг бэлтгэхэд оролцох,
- Төлөвлөж буй болон хэрэгжиж буй үйл ажиллагааны хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангах үүднээс төслийн хэрэгжилтэд оролцож буй бусад

байгууллага/талуудтай харилцаа холбоог тогтмол хангах, төслийн талаарх сүүлийн үеийн мэдээллийг талуудтай тогтмол солилцох,

- Төслийг дуусгавар болгох Техникийн хамтын ажиллагааны даалгаврыг гарын үсэг зурж баталгаажуулах арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах,
- ТХН-ийн захиргаа болон үйл ажиллагааны дотоод журмыг холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих, тухайлбал Санхүүгийн ажилтантай хамтран санхүүгийн гүйлгээний тайлангийн загваруудыг боловсруулах,
- Төлөвлөсөн арга хэмжээ, зардлын нэгдсэн жагсаалтыг хянаж, улирал бүр Төслийн Удирдах Хороонд хүргүүлэх зэрэг төслийн үйл ажиллагааны төлөвлөлт, төсөвлөлтийг удирдан зохион байгуулах.

Мэргэшлийн шаардлага

Боловсрол:

Барилгын инженер, бизнесийн удирдлага, төслийн менежмент эсвэл усан хангамж, усны нөөцийн менежментийн чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;

Туршлага:

Мэргэжлээрээ болон холбогдох чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан, хөрөнгө оруулалтын төсөлд 5-аас доошгүй жил ажилласан практик туршлагатай, үүний зэрэгцээ төслийн менежерээр ажиллаж байсан.

Олон улсын санхүүгийн байгууллага /ОУСБ/-аас санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, эсвэл ижил төстэй, нарийн түвэгтэй төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Инженерийн зураг төсөл, ЕСБХБ болон бусад ОУСБ-ын худалдан авалтын дүрмийг ашиглан худалдан авалт хийх, Монгол улсын болон олон улсын байгаль орчныг хамгаалах практик туршлагатай бол давуу тал болно.

Ур чадвар:

- Харилцааны өндөр соёлтой, төслийн нэгжийг манлайлах, удирдах чадвартай;
- Мэргэжлийн болон ажлын ёс зүйн өндөр мэдлэгтэй;
- Windows, Microsoft Outlook болон Office (Word, Excel, PowerPoint), Acrobat, Интернет, И-мэйл программыг чөлөөтэй хэрэглэдэг байх;
- Монгол, англи хэлний ярианы болон бичгийн өндөр мэдлэгтэй байх.

2. Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтан

Хийх ажлын цар хүрээ

Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан ажилтан нь төслийн менежерийн шууд удирдлаган дор ажиллах бөгөөд энэхүү Ажлын байрны чиг үүрэгт заасан бүх асуудлыг хариуцаж, төслийн хүрээнд хийгдэх байгаль орчин, нийгмийн хамгааллын бүх арга хэмжээг хэрэгжүүлэх болон зээл, буцалтгүй тусламж, төсөл болон бусад холбогдох гэрээ, гэрээнд тусгагдсан бүх ажлыг гүйцэтгэнэ. Ингэхдээ Зээлдэгчийг гэрээнд заасан бүх үүргээ биелүүлэхэд анхаарна.

Мэргэжилтэн нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ /БОНБУ/, олон улсын Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ /БОННУ/, Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө /БХТ/, Байгаль орчин, нийгмийн менежмент, мониторингийн төлөвлөгөөний дагуу шаардлагатай арга хэмжээний хэрэгжилтийг хангах, тайлагнах үүрэгтэй ба ингэхдээ ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого /ESP/ болон ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага /PRs/-д нийцүүлсэн байна.

Мэргэжилтэн нь байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, менежмент, нөөцийн үр ашиг, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, орон нутгийн иргэдэд үзүүлэх аливаа нөлөөллийг үр дүнтэй шийдвэрлэх талаархи Монгол Улсын хууль, тогтоомж, ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого /ESP/, ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага /PR/ болон бусад холбогдох шаардлагуудтай танилцана.

Тэрээр барилга, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх явцад холбогдох бүх талууд байгаль орчин, нийгмийн стандартыг дээд зэргээр мөрдөж ажиллахад анхаарч Орхон аймгийн нэрийн өмнөөс байгаль орчин, нийгмийн гэрээний асуудлыг хариуцна.

Дэлгэрэнгүй чиг үүрэг:

- Холбогдох баримт бичгүүд болон Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө /БОНУАТ/-ний хэрэгжилтийн нэг хэсэг болгон өнөөг хүртэл боловсруулсан баримт бичгүүдийг, түүний дотор ТХДН-ийн зөвлөхүүдийн боловсруулсан баримт бичгийг хянах,
- Төслийн байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын гүйцэтгэлийг тайлагнах журмыг Байгаль орчин, нийгмийн жилийн тайлан (AESR) –гийн дагуу боловсруулж ЕСБХБ-д хүлээлгэн өгөх. Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөний (БОНМТ) хэрэгжилтийн тайланг орон нутгийн байгаль орчны байгууллагуудад хүлээлгэн өгөх,
- ТХДН-ийн зөвлөхөөс зохион байгуулах байгаль орчин, нийгмийн хамгааллын талаарх сургалтуудад хамрагдаж, үүрэг даалгавар биелүүлэхэд нь хамтран ажиллах,
- ТХН-ийг төлөөлөх эсвэл төслийн менежер гэрээнд тусгагдсан байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудлаар ТХДН-ийн зөвлөх, гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчидтэй хэлэлцүүлэг явуулахад нь туслах,
- Төслийн ерөнхий БОНУАТ болон орон нутгийн БОНБУ-нд тусгагдсан БОНМТ-ний хүрээнд тухайн газар нутгийн болон гэрээний тухайлсан БОУАТ-г бэлтгэж хэрэгжүүлэх,

- Орон нутгийн БОНБУ-нд баримт бичгийг бэлтгэж, батлуулахаар ирүүлэх, гэрээт гүйцэтгэгчийн БОНМТ-г дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих,
- Тухайн газар нутагт зориулсан олон нийтийн оролцоог төлөвлөгөө бэлтгэж хэрэгжүүлэх,
- Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх механизмыг (GRM) журмын дагуу бий болгон үр дүнтэй хэрэгжүүлж, орон нутгийн оролцогч талуудтай тогтмол зөвлөлдөж, оролцогч талууд болон оршин суугчдаас ирүүлсэн санал, гомдлыг шуурхай, ил тод шийдвэрлэж, бүх гомдлыг Орхон аймгийн Засаг даргын Тамгын газар болон ЕСБХБ-д шуурхай мэдээлдэг байх,
- Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн тухай хууль, ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн бодлого болон БОНУАТ-ний шаардлагад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд Гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаанд тогтмол газар дээр нь очиж, хяналт тавьж, ЕСБХБ-тай тохиролцсон загварын дагуу тогтмол тайлан гаргах,
- Гүйцэтгэгчид болон ханган нийлүүлэгчдийн ЕСБХБ-ны холбогдох байгаль орчны бодлого, шаардлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх,
- Гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчдийг даалгавраа гүйцэтгэхэд шаардагдах баримт бичиг, журам, гарын авлага болон бусад материалаар хангах,
- Гүйцэтгэгчид болон ханган нийлүүлэгчдийн баримт бичиг, журмыг ЕСБХБ-ны шаардлагад нийцэж байгаа эсэхийг шалгаж, үр дүнтэй хэрэгжилтийг хангахад анхаарах,
- Шаардлагатай тохиолдолд хувийн зүгээс даалгаврын талаар нэмэлт тодруулга өгөх,
- Газар нүүлгэн шилжүүлэхэд үзүүлэх нөлөөллийг (хэрэв байгаа бол) багасгахын тулд зураг төслийн багтай нягт хамтран ажиллаж, газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг (шаардлагатай бол) бэлтгэж хэрэгжүүлэх. Мөн гомдол гаргах механизмыг хэрэгжүүлэх.

Мэргэшлийн шаардлага:

Боловсрол:

Байгаль орчин, нийгэм судлал, тухайн чиглэлээр инженер болон бусад холбогдох чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй.

Туршлага:

Байгаль орчин, нийгмийн хамгааллын чиглэлээр мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай, Монгол Улсын байгаль орчин, нийгэм, хөдөлмөрийн холбогдох хууль, тогтоомжийг болон олон улсын сайн туршлагыг хэрэглэж байсан байх.

Дараахь чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

Байгаль орчныг хамгаалах, нийгмийн хамгааллын чиглэлээр эсвэл төрийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн компанид талуудын оролцоог хангах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай;

Олон нийтийн оролцоог хангах, хурал, зөвлөгөөн зохион байгуулж байсан туршлагатай;

Олон улсын санхүүгийн байгууллагад тавигддаг байгаль орчин, нийгмийн хамгааллын шаардлагуудыг мэддэг;

Жендэрийн асуудлууд болон үнэлгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай.

Өөрийн эрхлэх асуудлын хүрээний Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн талаар мэдлэгтэй.

Ур чадвар:

- Монгол улсын болон олон улсын хэмжээнд байгаль орчин, нийгмийн хамгааллын чиглэлээр маш сайн практик мэдлэгтэй;
- Бие даан болон багаар ажиллах чадварыг эзэмшсэн;
- Мэргэжлийн болон ажлын ёс зүйн өндөр мэдлэгтэй;
- Windows, Microsoft Outlook болон Office (Word, Excel, PowerPoint), Acrobat, Интернет, И-мэйл программыг үйл ажиллагаандаа чөлөөтэй хэрэглэдэг байх;
- Монгол, англи хэлний ярианы болон бичгийн өндөр мэдлэгтэй байх.

3. Санхүүгийн ажилтан

Хийх ажлын цар хүрээ:

Санхүүгийн ажилтан нь ТХН-ийн санхүүгийн менежменттэй холбоотой бүх ажлыг хариуцна. Үүнд төслийн төлбөр тооцоог гүйцэтгэх, зээл, буцалтгүй тусламж, төслийн санхүүгийн гэрээтэй холбоотой асуудлуудыг нягтлан бодох бүртгэлийн стандарт, төлбөрийн бодлогын дагуу Орхон аймгийн Засаг дарга, Тамгын газар, Сангийн яам, ЕСБХБ-ны асуулгад хариу өгөх зэрэг багтана.

Дэлгэрэнгүй чиг үүрэг:

- Төсөвлөлт, хөрөнгийн урсгал, зарцуулалт, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, хөндлөнгийн аудитын асуудлуудыг багтаасан төслийн санхүүгийн удирдлагын зохистой тогтолцоо, туршлагыг хадгалах,
- Төслийн өдөр тутмын санхүүгийн ерөнхий удирдлагыг хариуцах, төслийн менежер болон төслийн хэрэгжилтэд оролцдог бусад талуудтай харилцах,
- ЕСБХБ болон Монгол Улсын Засгийн газрын бодлого, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, төсөв, санхүүгийн хяналт, аудитын журмын дагуу санхүүгийн журам, үйл явцыг үр ашигтай хэрэгжүүлэх, төслийн хөрөнгийн зохистой удирдлага, зарцуулалтыг хангах,
- Зардал, төлбөрийн нэхэмжлэлийг ТХН, аймгийн Засаг дарга, Сангийн яамаар батлуулах, зохих бичиг баримтыг бүрдүүлж, ханган нийлүүлэгч, зөвлөхүүдийн төлбөрийг гэрээний холбогдох нөхцөл, болзлын дагуу цаг тухайд нь шийдвэрлэх,
- ЕСБХБ-аас мөнгө авах хүсэлтээ, зардлын тайлан гэх мэт шаардлагатай дагалдах баримт бичгийн хамт цаг тухайд нь бэлтгэх,
- Тусгай дансны тохирлын хуулга, төслийн банкны дансны хуулга хөтлөх, баталгаажуулах, хянах,
- Төслийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн системийг бий болгож, хөтлөх,
- Төслийн зарцуулалтад хяналт тавьж, бүх төлбөрийн баримт, нэхэмжлэх, дагалдах баримт бичгүүдийг хянаж, хяналтанд үндэслэн төлбөрийн бүх хүсэлтийг бэлтгэж нэгтгэх, Банкны зарцуулалтын заавар, Засгийн газрын журмын дагуу төлбөрөөс чөлөөлөх, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг явуулах,
- Нийлүүлэлтийн болон барилгын ажил гүйцэтгэх тендерийн болон гэрээний баримт бичгүүдийг бэлтгэх, нэгтгэх, тэдгээрийн гэрээний биелэлтийн талаарх Инженерийн сар бүр болон явцын тайланг хянах,
- Төслийн гүйцэтгэл болон санхүүгийн зарцуулалтын тайланг батлагдсан ажлын төлөвлөгөөний дагуу тогтмол гаргаж, гэрээний нөхцөл, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэгч, зөвлөхүүдийн гүйцэтгэлд хяналт тавих, үнэлгээ хийх,
- Төслийн төлөвлөсөн үйл ажиллагаатай уялдуулан төслийн жилийн ажлын төлөвлөгөө, төсвийг Төслийн менежертэй хамтран гаргаж, төслийн төсвийг аймаг, улсын төсөвт зөв тусгаж, шинэчилсэн төслийн үйл ажиллагаанд үндэслэн төсвийг тогтмол шинэчилэх,

- Төслийн банкны данс хөтөлж, санхүүгийн бүх гүйлгээг цаг тухайд нь, үнэн зөв бүртгэж, ЕСБХБ, Сангийн яамны дүрэм, журмын дагуу санхүүгийн тайланг гаргаж, бүрдүүлэх,
- Төслийн гэрээний тайланг багтаасан нягтлан бодох бүртгэлийн хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу ЕСБХБ, хандивлагчид болон засгийн газрын шаардлагад нийцсэн санхүүгийн тайлангуудыг цаг тухайд нь гаргаж, хүргүүлэх,
- Шаардлагатай үед татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг бэлтгэж, ирүүлэх,
- Шаардлагатай бол ТХН-ийн янз бүрийн түвшинд, мөн ЕСБХБ, СЯ, орон нутгийн захиргаанд тайлан бэлтгэж гаргах,
- Төслийн хууль эрх зүйн гэрээнд заасан шаардлагын дагуу Төслийн жилийн аудитыг хугацаанд нь хийж дуусгах, Төслийн жилийн аудитын тайланг ЕСБХБ-д хүргүүлэхэд хөндлөнгийн аудиторуудад тусалж, хамтран ажиллах, хөндлөнгийн аудиторуудын дүгнэлтээр илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг шуурхай авах,
- Төсөл хэрэгжүүлэх явцад шаардлагатай гэж үзвэл Сангийн яам, Орхон аймгийн Засаг дарга, ЕСБХБ-ны санхүүгийн мэдээлэлтэй танилцах болон/эсвэл хүсэлтэд хариу өгөх,
- Төслийн бүх санхүүгийн бүртгэлийг хөтөлж, шинэчилэх, үүнд төсөл хаагдсаны дараа төслийн дансыг хаах зэрэг орно.

Мэргэшлийн шаардлага:

Боловсрол:

Санхүү, нягтлан бодох бүртгэл, бизнесийн удирдлага болон бусад ижил төстэй мэргэжлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;

Туршлага:

Нягтлан бодох бүртгэл ба/эсвэл санхүүгийн менежментийн чиглэлээр мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байх, ялангуяа олон улсын санхүүгийн байгууллага болон бусад олон улсын хөгжлийн байгууллагаас санхүүжүүлсэн төслүүдэд ижил төстэй чиг үүрэг гүйцэтгэж байсан бол давуу тал болно.

Ур чадвар:

- CFA, CPA, CA, ACCA, эсвэл түүнээс дээш санхүүгийн зэрэгтэй бол давуу тал болно.
- Нягтлан бодох бүртгэлийн бүртгэл хөтөлж, төслийн санхүүгийн тайлан гаргахад санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг ашиглаж байсан өмнөх ажлын туршлага, үүнд мэдээллийн системийн талаарх ойлголт хамаарна.
- Засгийн газар, Олон улсын санхүүгийн байгууллага болон бусад олон улсын хөгжлийн байгууллагуудын баримталж буй төсөл хэрэгжүүлэх бодлого, журмын талаар нарийн ойлголттой байх,
- Багаар үр дүнтэй, хамтран ажиллах чадвартай, хүнтэй харилцах харилцааны болон оролцооны ур чадвар сайтай,
- Компьютерийн өндөр мэдлэгтэй, нягтлан бодох бүртгэлийн программ болон MS Office программыг ашиглах өндөр чадвартай,
- Монгол, англи хэлний ярианы болон бичгийн өндөр мэдлэгтэй байх.